

МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны ... дугаар сарын ...-ны өдөр  
хот

Дугаар ...

Улаанбаатар

“Үнэт цаасны бүртгэлийн журам”-ыг  
шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6.4, 8.2, 10.16, 12.4, 16.2, 17.2, 18.2-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Үнэт цаасны бүртгэлийн журмыг 2015 оны \*\* дугаар сарын \*\*-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
3. Энэхүү тогтоолын 2-т заасан өдрөөс эхлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Үнэт цаасны бүртгэлийн журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан холбогдох дүрэм, журамдаа зохих өөрчлөлтийг оруулан 2015 оны \*\* дүгээр сарын \*\*-ны өдрийн дотор Хороогоор батламжлуулахыг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК /М.Болор/, “ҮЦТТТХТ” ХХК /Ж.Алдаржавхлан/-д тус тус үүрэг болгосугай.
5. Энэхүү тогтоолыг олон нийтэд мэдээллэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, зохицуулалттай этгээдүүдийн хүрээнд сургалт зохион байгуулах, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны зохицуулалтын газар /Т.Гандулам/-т тус тус даалгасугай.

ДАРГА

З.НАРАНТУЯА

## ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ЖУРАМ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ - НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмаар компанийн шинээр болон нэмж гаргасан хувьцаа, өрийн хэрэгсэлийг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ны нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэл /цаашид “үнэт цаасны бүртгэл” гэх/-д бүртгэх, үнэт цаасыг нийтэд танилцуулах, анхдагч зах зээлд арилжих, тайлагнах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хадгаламжийн бичиг гаргах болон бусад үүсмэл санхүүгийн хэрэгсэлийг бүртгэхтэй холбоотой харилцааг энэ журмаар зохицуулахгүй.

#### 2 дугаар зүйл. Нэр томъёоны тодорхойлолт

2.1. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар ойлгохоос гадна дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно:

2.1.1. “Хорооны бүртгэл” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, энэ журамд заасны дагуу Хорооноос нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлийг;

2.1.2. “Арилжаа эрхлэх байгууллагын бүртгэл” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49.1.2-т заасан журмаар тогтоосон ангиллын шалгуурыг хангасан компани болон түүний үнэт цаасыг бүртгэсэн арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийг;

2.1.3. “хүсэлт гаргагч” гэж үнэт цаасаа хөрөнгийн бирж, Хорооны бүртгэлд бүртгүүлэх, бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах, эсхүл бүртгэлээс хасуулах хүсэлт гаргаж буй хуулийн этгээд буюу үнэт цаас гаргагчийг;

2.1.4. “Бүрдүүлбэр”-т дараах зүйлийг ойлгоно

2.1.4.1. үнэт цаасны төрөл;

2.1.4.2. үнэт цаас гаргагчийн оноосон нэр;

2.1.4.3. үнэт цаасны нэрлэсэн үнэ;

2.1.4.4. зарласан үнэт цаасны тоо ширхэг;

2.1.4.5. эргэлтэд гаргасан үнэт цаасны тоо ширхэг;

2.1.4.6. арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй эсэх

2.1.4.7. хүү, хугацаа, хямдруулсан эсэх

2.1.4.8. хүү төлөх нөхцөл;

2.1.4.9. төлбөр хийгдэх нөхцөл;

2.1.4.10. өрийн хэрэгслийн хувьд түүнийг гаргах вальют

ХОЁРДУГААР БҮЛЭГ – ХҮСЭЛТ ГАРГАГЧ, АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГА,  
ХОРООНЫ ЭРХ, ҮҮРЭГ

### **3 дугаар зүйл. Хүсэлт гаргагчийн эрх, үүрэг**

3.1. Хүсэлт гаргагч нь анх удаа нийтэд санал болгон гаргах үнэт цаасаа бүртгүүлэх хүсэлтээ эхэлж арилжаа эрхлэх байгууллагад гаргах ба уг хүсэлтээ Хороонд зэрэг гаргаж болно.

3.2. Хүсэлт гаргагч нь үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасуулахад арилжаа эрхлэх байгууллагад эхэлж хандана.

3.3. Хүсэлт гаргагчийн гаргах үнэт цаасыг бүртгэхтэй холбоотой Хорооноос шаардсан альваа тодруулга, баримт бичгийг заасан хугацаанд хүргүүлнэ.

3.4. Төсөл хэрэгжүүлэхээр үнэт цаас гаргасан компани төсөл бүрэн хэрэгжиж дуусах хүртэл улирал бүр төслийн хэрэгжилтийн явцын тайлан, хөрөнгийн зарцуулалтын тайланг зардлын зүйл тус бүрээр гарган, нягтлан бодох бүртгэлийн улиралын тайлангийн хамт дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор Хороонд хүргүүлэхээс гадна өөрийн цахим хуудсаар нийтэд мэдээлэх үүрэгтэй.

3.5. Хүсэлт гаргагч нь арилжаа эрхлэх байгууллагын энэ журмын 4.5-д заасан шийдвэрийг эс зөвшөөрвөл Хороонд гомдол гаргах эрхтэй.

### **4 дүгээр зүйл. Арилжаа эрхлэх байгууллагын эрх, үүрэг**

4.1. Хүсэлт гаргагч нь арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн ангилал, түүний шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх болон үнэт цаасны танилцуулгын бүрдэл, санхүүгийн үзүүлэлт, бизнес төлөвлөгөө болон түүний эдийн засгийн үндэслэлийг арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн журмын дагуу хянаж Хорооны СЗХ\*\*\*02 тоот маягтын дагуу дүгнэлт гаргаж Хороонд хүргүүлнэ.

4.2. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хүсэлт гаргагчийн хувьд тухайн компани нь арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн шаардлагыг хангаж байгаа эсэх болон компанийн үнэт цаасыг давхар бүртгэж, арилжаалах боломжтой эсэх талаарх мэдэгдлийг энэ журмын 4.1-т заасан маягтын хамт Хороонд хүргүүлнэ.

4.3. Өрийн хэрэгсэл гаргах хүсэлт гаргагчийн хувьд түүний эргэн төлөлтийн баталгаа, барьцаа хөрөнгийн бүртгэлийг хөтлөх, барьцааны зүйлд бүртгүүлэх бөгөөд эргэн төлөлтөд хяналт тавина.

4.4. Арилжаа эрхлэх байгууллага нь үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах шийдвэр гаргасан тохиолдолд энэ тухай ажлын 3 хоногт багтаан Хороонд мэдэгдэнэ.

4.5. Арилжаа эрхлэх байгууллага нь хүсэлт гаргагчийн анх удаа болон нэмж гаргах үнэт цаасыг өөрийн бүртгэлд бүртгэхээс татгалзсан тохиолдол бүрт энэ тухай мэдэгдлийг дэлгэрэнгүй тайлбарын хамт Хороонд хүргүүлнэ.

4.6. Үнэт цаас гаргагч нь компанийн хэлбэрийг өөрчлөх шийдвэр гаргасан, үндсэн болон хүүгийн төлбөр төлөгдсөнтэй холбоотойгоор үнэт цаасаа бүртгэлээс хасуулах хүсэлтийг арилжаа эрхлэх байгууллагад эхэлж гаргах ба арилжаа эрхлэх байгууллага нь үнэт цаасыг бүртгэлээс хасахтай холбоотойгоор хувьцаа эзэмшигчдийн эрхийг хуульд заасан журмын дагуу зохих хугацаанд хэрэгжүүлсэн эсэхэд хяналт тавьж бүртгэлээс хасах шийдвэр гарсан тохиолдолд энэ тухай мэдэгдэл болон Хорооны СЗХ\*\*\*05 тоот маягтын дагуу гаргасан дүгнэлтийг ажлын 3 хоногт багтаан Хороонд хүргүүлнэ.

4.7. Бүртгэлтэй компани нь арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн шалгуур, хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс хасагдах үндэслэл болох ба уг шалтгаанаар бүртгэлээс хасах тухай шийдвэр гарсан тохиолдолд энэ тухай мэдэгдлийг ажлын 3 хоногт багтаан үнэт цаас гаргагч болон Хороонд хүргүүлнэ.

### **5 дугаар зүйл. Хорооны эрх, үүрэг**

5.1. Хороо хүсэлт гаргагчийн нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх, түүнд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасуулах хүсэлтийг хянах явцад дараах арга хэмжээг авч болно.

5.1.1. Хорооны бүртгэлд бүртгүүлэх хүсэлттэй холбоотой гэж үзсэн аливаа асуудлаар хүсэлт гаргагч болон түүний мэргэжлийн зөвлөхөөс асуулт асууж, тайлбар авах;

5.1.2. Хорооны бүртгэлд бүртгүүлэх хүсэлттэй холбоотой гэж үзсэн аливаа мэдээллийг хянах;

5.1.3. хүсэлт гаргагчаас хүргүүлсэн мэдээллийг Хорооноос тогтоосон хэлбэрээр баталгаажуулахыг шаардах;

5.1.4. хүсэлт гаргагчийн үйл ажиллагаа, ирүүлсэн баримт бичиг нь бодит байдалд нийцэж байгаа эсэхэд дүгнэлт гаргах зорилгоор газар дээрх үзлэгийг хийх.

5.2. Хүсэлт гаргагч, түүний мэргэжлийн зөвлөхөөс Хороонд ирүүлсэн тайлбар, тодруулга нь үнэт цаасны танилцуулгад тусгагдаагүй, түүнд заасан мэдээллээс зөрүүтэй бол Хороо энэ тухай арилжаа эрхлэх байгууллагад мэдэгдэж зохих өөрчлөлтийг оруулна.

5.3. Энэ журмын 3.5-д заасны дагуу хүсэлт гаргагчаас Хороонд гомдол гаргасан тохиолдолд Хороо арилжаа эрхлэгч байгууллагын шийдвэр нь үндэслэлтэй эсэхэд хяналт тавих бөгөөд арилжаа эрхлэх байгууллагаас уг асуудалтай холбоотой нэмэлт тайлбар, мэдээлэл шаардаж болно.

5.4. Хороо арилжаа эрхлэх байгууллагын энэ журмын 4.4-т заасан бүртгэлээс хасах тухай шийдвэр, Хорооны СЗХ\*\*\*03 маягтын дагуу гаргасан дүгнэлтийг тус тус үндэслэн үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг Хорооны бүртгэлээс хасна.

5.5. Хороо энэ журмын 4.7-д заасан үндэслэлээр арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс хасагдсан компанийг хаалттай хувьцаат компанийн бүртгэлд бүртгэнэ.

5.6. Хүсэлт гаргагчийн үнэт цаасыг бүртгэх, бүртгэлтэй үнэт цаасны энэ журмын 5.7-д зааснаас бусад бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах, үнэт цаасыг бүртгэлээс хасах асуудлыг Хорооны хуралдаанаар хэлэлцэнэ.

5.7. Энэ журмын 2.1.4.2, 2.1.4.4, 2.1.4.6-д заасан үнэт цаасны бүрдүүлбэрт орох өөрчлөлтийг Хорооны даргын шийдвэрээр бүртгэнэ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ - ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭХ, БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

### **6 дугаар зүйл. Хороонд бүртгүүлэх, бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлт гаргах**

6.1. Хороо энэ журмын 4.1, 4.2-т заасан дүгнэлт, Хороонд нэмж ирүүлсэн бусад баримт бичгийг үндэслэн үнэт цаас, түүний танилцуулгыг Хорооны үнэт цаасны бүртгэлд бүртгэх, түүнд өөрчлөлт оруулах тухай шийдвэр гаргана.

6.2. Хүсэлт гаргагч нь үнэт цаасыг бүртгүүлэх, бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлтийг Хороонд гаргах бөгөөд дараах баримт бичгийг хавсаргана.

6.2.1. өргөдөл /Хорооны СЗХ \*\*\*01 маягтын дагуу/;

6.2.2. арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэр;

6.2.3. арилжаа эрх байгууллагын 'Бүртгэв' тэмдэглэл бүхий үнэт цаасны танилцуулга;

6.2.4. үнэт цаас гаргах, түүнд өөрчлөлт оруулах эрх бүхий этгээдийн шийдвэр, холбогдох нотлох баримт;

6.2.5. хууль, үнэлгээ, аудитын болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.8-д заасан хөндлөнгийн шинжээч, мэргэжилтэн үнэлэлт, дүгнэлт гаргасан бол тэдгээрийн дүгнэлт;

6.2.6. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн баримт;

6.3. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монголын арилжаа эрхлэх байгууллага болон Хороонд бүртгүүлэн үнэт цаасаа нийтэд арилжаалахад энэ журам нэгэн адил хамаарна.

6.4. Хүсэлтийг Хороо хүлээн авч Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9.6-д заасан хугацааг тоолж эхлэнэ.

6.5. Энэ журмын 5.5-д заасан Хорооны хуралдаанд хүсэлт гаргагч компанийн эрх бүхий албан тушаалтан болон энэ журмын 6.1.6-д заасан үнэлэлт, дүгнэлт гаргасан этгээдийг оролцуулж, шаардлагатай тайлбар, тодруулгыг авч болно.

## **7 дугаар зүйл. Үнэт цаасны бүртгэлд бүртгэх, бүртгэхээс татгалзах**

7.1. Хороо энэ журамд заасны дагуу бүрэн гүйцэд хүргүүлсэн баримт бичгийг хянаж, хууль болон энэ журамд заасан бүртгэхээс татгалзах үндэслэл байхгүй бол үнэт цаас, түүний танилцуулгыг бүртгэж үнэт цаасны бүртгэлд бүртгэх тухай тогтоол гаргана.

7.2. Хороо Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9.10-т заасан болон арилжаа эрхлэх байгууллагын бүртгэл бүртгүүлээгүй хүсэлт гаргагчийн үнэт цаасыг бүртгэхээс татгалзана.

7.3. Хороо үнэт цаас, түүний танилцуулгыг бүртгэх тухай шийдвэрийг үнэт цаас гаргагч, арилжаа эрхлэх болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад тус тус хүргүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

7.4. Хүсэлт гаргагч нь арилжаа эрхлэх байгууллага болон Хороонд хүргүүлсэн танилцуулга түүнд хавсаргасан бүх бичиг баримт, хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт зэрэг бүртгүүлэхтэй холбоотой бүх бичиг баримтыг Хорооны бүртгэлд бүртгэх тухай тогтоол гарснаас хойш таван жилийн хугацаанд хадгална.

7.5. Хороо нь үнэт цаасыг тодорхой үйл явдлаас шалтгаалах болзолтойгоор Хорооны бүртгэлд бүртгэхгүй.

7.6. Хороо үнэт цаасыг бүртгэх үед компанийн хяналтын багцыг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчийн үнэт цаасыг тодорхой хугацаанд тусгаарлаж болох бөгөөд тусгаарлалтын хугацааг нэг удаа сунгаж болно.

7.7. Энэ журмын 7.6-д заасан тусгаарлагдсан хувьцааг тусгаарлалтаас чөлөөлөх нөхцөл бүрдсэн гэж Хороо үзвэл чөлөөлөх тухай тогтоол гаргана.

7.8. Хүсэлт гаргагч нь үнэт цаасыг бүртгэхээс татгалзсан тухай Хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар Хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлд холбогдох журмын дагуу гомдол гаргах эрхтэй.

## **8 дугаар зүйл. Үнэт цаасны танилцуулгыг олон нийтэд танилцуулах**

8.1. Хороонд бүртгүүлээгүй үнэт цаасны танилцуулгыг нийтэд танилцууж, санал болгохыг хориглоно.

8.2. Стратегийн хөрөнгө оруулагч болон мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч этгээд, андеррайтерийн компанитай үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах талаар урьдчилан яриа, хэлэлцээр хийснийг нийтэд танилцуулж, санал болгон сурталчилсанд тооцохгүй.

8.3. Үнэт цаас гаргагч болон түүний андеррайтер нь Хороонд бүртгүүлсэн үнэт цаасны танилцуулгыг нийтэд үнэ төлбөргүй хүргэх бөгөөд сонирхсон бүх этгээд танилцах боломжийг хангасан байна.

8.4. Хороонд бүртгэгдсэн танилцууллагад тусгагдсанаас өөр агуулгатай мэдээлэл, нэмэлт мэдээлэл түгээхийг хориглоно.

## **9 дүгээр зүйл. Анхдагч зах зээлд арилжаалах, тайлагнах, бүртгэлийг хүчингүй болгох**

9.1. Үнэт цаас гаргагч болон андеррайтер нь үнэт цаасыг Хороонд бүртгүүлсэнээс хойш зургаан сарын хугацаанд анхдагч зах зээлд гарган нийтэд санал болгон арилжаална.

9.2. Үнэт цаасыг нийтэд танилцуулах ажиллагаа дуусгавар болсон үед Хороонд бүртгэгдсэн танилцуулгад заасан арга хэлбэрээр үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулна.

9.3. Андеррайтер, эсхүл үнэт цаас гаргагч нь үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх тухай хүсэлтийг уг ажиллагааг эхлүүлэхээс ажлын гурваас доошгүй өдрийн өмнө Хороонд гаргах бөгөөд хүсэлтэд уг ажиллагааг явуулах хугацаа, хуваарийг тодорхой заасан байна.

9.4. Анхдагч зах зээлд байршуулахаар захиалгын бүртгэл хийх, эсхүл арилжаалах хугацаа нь захиалгын бүртгэл эхэлсэн эсхүл үнэт цаасыг нийтэд санал болгон арилжаалж эхэлсэн өдрөөс хойш нэг сараас илүүгүй байна.

9.5. Нийтэд санал болгон нэмж гаргах үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд энэ журмын 9.1, 9.4-т заасан хугацаа нэгэн адил хамаарна.

9.6. Анхдагч зах зээлийн арилжааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12.7-д зааснаас гадна дараах нөхцөлд амжилттай явагдсанд тооцно.

9.6.1. Нийт 50 болон түүнээс дээш хөрөнгө оруулагчид үнэт цаасыг худалдан авсан;

9.6.2. Үнэт цаасны танилцуулгад заасан шаардлагатай хувь, хэмжээний санхүүжилт татсан.

9.7. Үнэт цаасын танилцуулгад заасан бол энэ журмын 9.6.2-т заасан хэмжээнд арилжаалагдаад үлдсэн хувьцааг зарласан хувьцаанд бүртгэнэ.

9.8. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа анхдагч зах зээлд тодорхой хэмжээгээр багцлан арилжаалж болно.

9.9. Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжаа, эсхүл захиалгын бүртгэл явагдаж дууссанаас хойш ажлын гурван өдөрт багтаан арилжааны тайланг хавсралт 2-ын дагуу Хороонд ирүүлнэ.

9.10. Энэ журмын 9.6-д заасан нөхцөл бүрдээгүй тохиолдолд Хороо тухайн үнэт цаасны бүртгэлийг хүчингүй болгож, анхдагч зах зээлийн арилжааны хэлцлийг буцаана.

9.11. Үнэт цаас гаргагч нь энэхүү журмын 9.13-т заасан хугацаанд багтааж үнэт цаасны гүйлгээний товч тайланг нийтэд мэдээлнэ. Хэрэв нээлттэй компани болон өөрчлөгдөж анх удаагаа хувьцаагаа нийтэд санал болгон худалдсан бол уг мэдээлэлд компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын товыг тусгасан байна.

9.12. Хороо энэ журмын 9.9-т заасан тайланг хүлээн авч анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсан, аливаа зөрчил гараагүй гэж үзвэл үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэхийг зөвшөөрсөн тухай албан бичгийг ажлын гурван өдөрт багтаан арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.

9.13. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа анхдагч зах зээлд захиалгын бүртгэлийн аргаар байршуулсан бол энэ журмын 9.9-т заасан тайланг Хороонд хүргүүлэх ба анхдагч зах зээлийн захиалга амжилттай явагдсан, аливаа зөрчил гараагүй гэж үзвэл Хороо үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэл хийх зөвшөөрөл олгоно.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ - ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭЛЭЭС ХАСАХ

### 10 дугаар зүйл. Үнэт цаасыг бүртгэлээс хасах

10.1. Үнэт цаас гаргагч нь хязгаарлагдмал хариуцлагатай компани болж компанийн хэлбэрийг өөрчлөх, татан буугдах болон хуульд заасан бусад тохиолдолд үнэт цаасыг бүртгэлээс хасна.

10.2. Арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй эсхүл тухайн байгууллагын шалгуурыг хангаагүйн улмаас түүний бүртгэлээс хасагдсан компани нь үнэт цаасаа бүртгэлээс хасуулах хүсэлтэд дараах баримт бичгийг хавсарган Хороонд хүргүүлэнэ.

10.2.1. өргөдөл /хавсралт ...-ын дагуу/;

10.2.2. арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс хассан тухай шийдвэр;

10.2.3. үнэт цаасыг бүртгэлээс хасахад татгалзах зүйлгүй тухай арилжаа эрхлэх байгууллагын тодорхойлолт;

10.2.4. үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаас тухайн компанийн үнэт цаасыг бүртгэлээс хасахтай холбоотой санал, дүгнэлт, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажилласан эсэх тухай тодорхойлолт болон компанийн хувьцаа эзэмшигчийн тусгаарлагдсан хувьцааны талаарх мэдээ;

10.2.5. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн баримт.

10.3. Үнэт цаас гаргагч нь хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрхийг бүрэн хэрэгжүүлж, хууль болон энэ журамд заасан баримт бичгийг бүрэн бүрдүүлж ирүүлсэн тохиолдолд түүний үнэт цаасыг Хорооны бүртгэлээс хасна.

10.4. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага компанийн хэлбэрээ өөрчилсөн үнэт цаас гаргагчийн хувь эзэмшигчдийн дэлгэрэнгүй мэдээлэлийг үнэт цаас гаргагч болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ.

10.5. Үнэт цаасыг бүртгэлээс хасах тухай Хорооны шийдвэр гарахад Хорооны Ажлын алба үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах бөгөөд энэ тухай ажлын 10 хоногт багтаан хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ.

## ТАВДУГААР БҮЛЭГ - ХАРИУЦЛАГА

### 11 дүгээр зүйл. Хариуцлага

11.1. Энэ журмыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай болон бусад хууль тогтоомжид заасан захиргааны хариуцлагыг Хорооны улсын байцаагч ногдуулна.

11.2. Энэ журмын 1-д заасан захиргааны хариуцлага хүлээлгэсэн нь тухайн этгээдийн бусдын өмнө хүлээсэн үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

~oOo~

Хавсралт 1 – Үнэт цаас бүртгүүлэх өргөдөл

Хавсралт 2 – Анхдагч зах зээлийн арилжааны тайлан

Хавсралт 3 – Үнэт цаасыг бүртгэлээс хассантай холбоотойгоор хувьцаа эзэмшигчдэд хүргэх хувьцааг эргүүлэн худалдан авах тухай зарын загвар